**“ЛИМИТЭД ЭКО ПРОТЕКТ” ХХК**
**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА**

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ “ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ” БАРИХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


***Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 7-р хороо 11-р хороолол***
***Их тойруу 82, Одкон холдинг 309а тоот***
***Утас: 99296506***


**2024 ОН**

# АГУУЛГА


НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........................................................ 4

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл ........................................................ 5

1.2 Төслийн байршил ........................................................ 5

1.3 Төслийн хүчин чадал ........................................................ 7

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ........................................................ 11

2.1 Уур амьсгал ........................................................ 11

2.2 Геологийн тогтоц ба геоморфологи ........................................................ 11

2.3 Гадаргын ус ........................................................ 12

2.4 Газрын доорх ус ........................................................ 13

2.5 Хөрсөн бүрхэвч ........................................................ 14

2.6 Ургамлан бүрхэвч ........................................................ 15

2.7 Амьтан ........................................................ 15

2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг ........................................................ 15

2.9 Нийгэм эдийн засаг ........................................................ 17

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ........................................................ 18

3.1 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл ........................................................ 18

3.2 Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл ........................................................ 18

3.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл ........................................................ 18

3.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл ........................................................ 18

3.5 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл ........................................................ 19

3.6 Нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл ........................................................ 19

3.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ ........................................................ 19

3.8 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж ........................................................ 20

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ........................................................ 21

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........................................................ 22

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........................................................ 28

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........................................................ 29

НАЙМ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........................................................ 33

ЁС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........................................................ 33

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ........................................................ 35

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ........................................................ 36

АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН

**ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ** ....................38

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн мэдээлэл ....................5
Хүснэгт 2.Төслийн координат ....................5
Хүснэгт 3. 2024 онд хийгдэх ажил ....................7
Хүснэгт 4. Төсөлд ашиглаглах техник ....................7
Хүснэгт 5. Төслийн талбайд ажиллах ажилчдын мэдээлэл ....................7
Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн нэгдсэн зардал ....................21
Хүснэгт 7. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө ....................22
Хүснэгт 8.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ....................29
Хүснэгт 9. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө ....................33
Хүснэгт 10. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө ....................33
Хүснэгт 11. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө ....................35
Хүснэгт 12. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ....................36
Хүснэгт 13. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө....................38

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг ....................7
Зураг 2. Төслийн талбайн зураг төсөл ....................8
Зураг 3. А, Б корпус ....................9
Зураг 4. Барилгажих талбай ....................9
Зураг 5. Төслийн өнөөгийн байдал ....................10
Зураг 6. Төслийн талбайн гадаргын усны зураглал ....................12
Зураг 7. Төслийн талбайд ойр байрлах худаг ....................14
Зураг 8. Төслийн талбайн дархан цаазат газар ....................16

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны хооронд 2015 оны 10 дугаар сарын 23 -ны өдөр "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр –VI: Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах" төслийн бэлтгэл ажлыг хангах техник туслалцааны төслийн гэрээ байгуулагдсан. Энэхүү техник туслалцааны төсөлд Зөвлөх үйлчилгээ үзүүлэх Олон улсын Зөвлөх багаар ХБНГУ-ын "Management4Health" компани шалгарсан ба тус баг 2016 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн Техник туслалцааны төслийг хэрэгжүүлж байна. Уг Техник туслалцааны Бэлтгэл төсөл нь Японы Ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр дараах зорилго зорилтууд, бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр 2019-2029 онуудад хэрэгжих "Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах" төслийн бэлтгэл үйл ажиллагааг ханган, зээлийн төслийн баримт бичгүүдийг боловсруулан ажиллаж байна. Энэхүү АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн төсөл нь дараах зорилго, зорилтуудын хүрээнд 2019-2029 онуудад хэрэгжинэ.

Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-VI төслийн Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хэсгийн хүрээнд хэрэгжих "Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг"-ийн өргөтгөлийн барилгын шинээр барьж байгуулах төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 23-р хорооны нутаг дэвсгэрт Богдхан уулын дархан цаазат газрын Арцатын аманд Нисэх, Яармагийн хатуу хучилттай авто замаас 200 м зайтай оршино.

Энэхүү төсөл нь АХБ-ны олон үе шатат санхүүжилтийн хөтөлбөр (ОҮШСХ)-ийн загвараар санхүүжигдэнэ. Олон үе шатат санхүүжилтийн хөтөлбөр нь эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын дунд, урт хугацааны түншлэл бий болгох, анхан шатны болон хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний удирдлага, санхүүжилт, мэдээллийн технологийн чадавхийг бэхжүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилго бүхий бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх боломжийг олгох юм. ОҮШСХ нь (i) АХБ-ны Монгол улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөндтуссан (2017 – 2019); (ii) АХБ-ны Монгол улсад хамтран ажиллах стратегитай (2017-2020) уялдаж буй бөгөөд энэ нь эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зорилтын хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар нийгмийн хөгжлийг дэмжих үзэл баримтлалтай нийцэж байхаас гадна; (iii) АХБ-ны эрүүл мэндийн салбарт 2015 – 2020 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн гурван чиглэлтэй уялдаж байгаа юм.

## *1.1 Төслийн ерөнхий мэдээлэл*

Нийслэлийн Эрүүл Мэндийн Газраас УБ хотод үйл ажиллагаа явуулж буй АЭМТ-үүдийн байршил, ачаалал, үйлчилгээний хамрах хүрээ зэргийг тооцон үзсэний үндсэн дээр дараах 4 өрхийн эмнэлгийг сонгон авч төслийн 1-р үе шатанд хамруулахаар шийдвэрлэсэн.

*Хүснэгт 1. Төслийн мэдээлэл*

| Төслийн нэр | “Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилга барих” төсөл |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч | Эрүүл мэндийн яам, Эмзэг Бүлгийн Иргэдийн Эрүүл Мэндийн Тусламж Үйлчилгээний Хүртээмжийг Сайжруулах Хөрөнгө Оруулалтын Хөтөлбөр ” төслийн нэгж |
| Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж – 2 Сүхбаатар дүүрэг 14210, Улаанбаатар хот, Монгол улс, Утас 976-11-317920 |
| Төсөл санхүүжүүлэгч | Азийн хөгжлийн банк (АХБ) |
| Барилгын ажил гүйцэтгэгч | Чайна рейлвэй ферст групп |
| Улсын бүртгэлийн дугаар | 000006956 |
| Регистрийн дугаар | 9140433 |
| Холбоо барих дугаар | 80013666 |

## *1.2 Төслийн байршил*

Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-VI төслийн Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хэсгийн хүрээнд хэрэгжих “Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг”-ийн өргөтгөлийн барилгын шинээр барьж байгуулах төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 23-р хорооны нутаг дэвсгэрт Богдхан уулын дархан цаазат газрын Арцатын аманд Нисэх, Яармагийн хатуу хучилттай авто замаас 200 м зайтай оршино.

*Хүснэгт 2.Төслийн координат*

| № | E | N |
|---|---|---|
| А ТАЛБАЙ | | |
| 1 | 106º 49´ 58.492´´ | 47º 52´ 7.939´´ |
| 2 | 106º 49´ 58.574´´ | 47º 52´ 7.926´´ |
| 3 | 106º 49´ 59.150´´ | 47º 52´ 7.041´´ |
| 4 | 106º 50´ 0.920´´ | 47º 52´ 7.172´´ |
| 5 | 106º 50´ 1.285´´ | 47º 52´ 7.122´´ |
| 6 | 106º 50´ 1.455´´ | 47º 52´ 7.066´´ |
| 7 | 106º 50´ 5.300´´ | 47º 52´ 1.245´´ |
| 8 | 106º 50´ 2.398´´ | 47º 52´ 0.384´´ |
| 9 | 106º 50´ 1.882´´ | 47º 52´ 1.121´´ |
| 10 | 106º 49´ 59.487´´ | 47º 52´ 1.151´´ |
| 11 | 106º 49´ 55.855´´ | 47º 52´ 0.397´´ |
| 12 | 106º 49´ 53.394´´ | 47º 52´ 4.248´´ |
| 13 | 106º 49´ 53.189´´ | 47º 52´ 4.238´´ |
| 14 | 106º 49´ 52.094´´ | 47º 52´ 5.984´´ |
| | | 39399.00 м2 |
| Б ТАЛБАЙ | | |
| 1 | 106º 49´ 59.636´´ | 47º 52´ 7.419´´ |

| | | |
|---|---|---|
| 2 | 106º 49´ 59.472´´ | 47º 52´ 7.681´´ |
| 3 | 106º 50´ 0.372´´ | 47º 52´ 7.937´´ |
| 4 | 106º 50´ 0.623´´ | 47º 52´ 7.571´´ |
| 5 | 106º 50´ 0.381´´ | 47º 52´ 7.429´´ |
| | | 250.000 м2 |
| | В ТАЛБАЙ | |
| 1 | 106º 50´ 24.862´´ | 47º 51´ 24.589´´ |
| 2 | 106º 50´ 26.183´´ | 47º 51´ 25.363´´ |
| 3 | 106º 50´ 27.662´´ | 47º 51´ 24.377´´ |
| 4 | 106º 50´ 26.740´´ | 47º 51´ 23.684´´ |
| 5 | 106º 50´ 24.973´´ | 47º 51´ 24.489´´ |
| | | 1500.00 м2 |
| | | НИЙТ ТАЛБАЙ ХЭМЖЭЭ 41149 М.КВ |






*Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг*

## 1.3 Төслийн хүчин чадал

*Хүснэгт 3. 2024 онд хийгдэх ажил*

| № | Хийгдэх ажил | Талбай хэмжээ |
|---|---|---|
| 1 | Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгийн хөрс хуулалт хийх талбай | 10900 |
| 2 | Хан Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгийн барилгын ажил хийгдэх талбай | 23382 |

*Хүснэгт 4. Төсөлд ашиглаглах техник*

| № | Тоног төхөөрөмж | Тоо хэмжээ |
|---|---|---|
| 1 | Ачааны машин (10 тонны даац) | 4 |
| 2 | Экскаватор (35000 LB ) | 2 |
| 3 | Автокран (5 тн даац) | 1 |
| 4 | Будах төхөөрөмж | 4 |
| 5 | Гагнуурын хэсэг / цахилгаан/ | 2 |
| 6 | Гагнуур /хийн/ | 2 |
| 7 | Компрессор | 4 |
| 8 | Өргөгч | 3 |
| 9 | Бетон зуурагч | 2 |
| 10 | Цахилгаан хөрөө | 5 |
| 11 | Металл зүсэгч | 2 |
| 12 | Теодолит | 2 |
| 13 | Шалны чичиргээ | 3 |

*Хүснэгт 5. Төслийн талбайд ажиллах ажилчдын мэдээлэл*

| **№** | **Боловсон хүчин** | **Нийт ажилчид** |
|---|---|---|
| 1 | Менежер | 20 |
| 2 | Засварын ажилчин | 25 |
| 3 | Бетоны ажилчин | 5 |
| 4 | Цахилгаанчин | 2 |
| 5 | Арматурчин | 10 |
| 6 | Гагнуурчин | 5 |
| 7 | Хэмжигч | 3 |
| 8 | Шатны шат | 25 |

| | | |
|---|---|---|
| 9 | Өргөгч | 8 |
| 10 | Суулгагч | 30 |
| 11 | Чимэглэгч | 25 |
| 12 | Ерөнхий ажилчид | 15 |
| 13 | Нийт | 173 |



*Зураг 2. Төслийн талбайн зураг төсөл*

Тус эмнэлэг нь 1980 оны 4-р сард Ажилчны районы хүүхдийн нэгдсэн эмнэлэг нэртэйгээр байгуулагдсан, хэвтэн эмчлэх 120 ортой, нэг ээлжиндээ 300 хүүхдэд үйлчлэх хүчин чадалтай поликлиниктэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Эзэмшиж байгаа нийт эдэлбэр газрын 19 %-д барилга байгууламж баригдсан ба 1.5 га талбайг зүлэгжүүлж нийт бут сөөг 400 ш, шилмүүст мод 168 тарьж ногоон байгууламж байгуулсан нь нийт эдэлбэр газрын 42 %-ийг эзэлж байна. Үлдсэн газрын 4%- нь маш их эвдрэл бохирдолтой байна. Төслийн 3,6 га эдэлбэр газрыг заагласан хашаа нь байхгүй. Нэгдсэн эмнэлгийн үндсэн барилга нь 3 хэсгээс бүрэлдсэн төв байр нь 3 давхар, баруун талын жигүүр нь 2 давхар энэ 2 хэсгийг холбосон хүзүүвч нь 1 давхар барилга. Давхар тус бүр нэг түвшингийн 3 метрийн өндөртэй. Том хэмжээтэй танхим байхгүй. Төв байр урагшаа 3, хойшоо 4 гарцтайгаас 2 гарцыг нэмж өргөтгөсөн. Тус барилга нь бетонон суурьтай 61 см зузаан тоосгон ханатай бетонон хавтан хучилттай, хар цаасан дээвэртэй. Эмнэлгийн эмчилгээний А корпус нь 3 давхар нийт 106 өрөөтэй, Б корпус нь 2 давхар 32 өрөөтэй. Нийтдээ 8170 м.кв талбайтайгаас ашигтай талбай 4637.27 м.кв. Суурь болон дээврийн хэсэгтээ техникийн давхар болон подвал хонгилтой. Инженерийн шугам сүлжээг хонгилын системээр шийдсэн. Барилгын суурийн гүний хэмжээг нарийвчлан мэдэхгүй болович хонгилын системийн инженерийн шугамаас харахад 3-4 метрийн гүнтэй байх боломжтой.



*Зураг 3. А, Б корпус*



*Зураг 4. Барилгажих талбай*






*Зураг 5. Төслийн өнөөгийн байдал*

# ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 2.1 Уур амьсгал

Төсөл хэрэгжих талбайн цаг уурын Их сургууль, Буянт-Ухаа станцуудын 2010-2023 оны мэдээг ашиглан боловсруулсан бөгөөд Улаанбаатар хотын хэмжээнд авч үзлээ. Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -38.30С хүрдэг, үнэмлэхүй их температур нь 36.90С хүрдэг, үнэмлэхүй их бага температурын агууриг нь (75.20С) эрс тэс ялгаатай. Жилийн дундаж температур нь 0.40С, хамгийн хүйтэн I сарын дундаж температур -21.3°С бол15 хамгийн дулаан сар болох YII сарын дундаж температур 19.50С байдаг байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 257.1 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 173.1 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 89 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

Салхины зонхлох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруунаас нийт салхины чиглэлийн 22.1% баруун хойноос, хойноос 20%, баруунаас 13.5% давтагдалтай байдаг. Салхины хурдны олон жилийн дундаж нь төдий л ихгүй ойролцоогоор 2.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг байна.

## 2.2 Геологийн тогтоц ба геоморфологи




Улаанбаатар хотын Хан-Уул нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга баригдах талбай, түүний орчмын бүс нутагт делювийн хурдасны геологи-гарал үүслийн комплекс (QIII-IV) тархжээ. Дээд дөрөвдөгч орчин үеийн делювийн хурдас тус уулын хажуу, бэл хормойн хэсгээр маш өргөн тархах бөгөөд элюви-делювийн хурдас болон үндсэн чулуулгийг хучин тогтоно. Хурдсын бүрэлдэхүүнд элсэнцэр шаврансараар чигжигдсэн хайр, хайрга, хайргархаг элсэнцэр, шаврансар зонхилох ба ховроор элс тохиолдох бөгөөд зузаан нь хажуугийн дээд хэсгээс доошоогоо ихсэж 1-15 м хүрнэ.

*Газар хөдлөл*

1959 онд Оросын мэргэжилтэн В.П.Солоненко БНМАУ (хуучин нэрээр)-ын нутаг дэвсгэрийн чичирхийллийн мужлалын анхны схем боловсруулсан нь “Улаанбаатарын чичирхийллийн мужлал” ном бичих үндэсийг тавьсан байна. Уг номд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн болон Улаанбаатар хотын оршин буй нутгийн чичирхийлэл, газар хөдлөлийн холбогдолтой судалгааны материал, дүгнэлтийн тодотгол, баяжуулалтын зураг, хот төлөвлөлтийн зөвлөмж зэрэг өргөн хүрээтэй асуудлыг тусгажээ. Үүний дүнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн чичирхийллийн мужлалын тойм зураг боловсруулж, чичирхийллийг 6, 7, 8 баллын 3 хэсэгт хуваан тогтоожээ.

## 2.3 Гадаргын ус

Хотын нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх 148 км урт Туул голд Асралт хайрхан уулнаас эх авсан Гачуурт, Тэрэлж, Толгойт, Улиастайн голууд цутгана. Туул голын ус хуримтлуулах ай сав 6300 км2 талбайг хамарна. Голын үндсэн тэжээмж агаар мандлын хур тунадас бөгөөд 90 орчим хувь байдаг. Мөн хот дундуур урсан өнгөрөх зүүн Сэлбийн гол Хэнтийн салбар уул болох Их Баян уулын өврөөс эх аван урсах ба өөрийнхөө гольдролын дагуу Хандгайт, Шарга морьт, Сэлх, Бэлх, Чингэлтэй, Ганц худгийн гол зэрэг олон жижиг цутгалтай голын сав газрыг үүсгэнэ. Сэлбэ гол хотоос хойш 35 км эх авч Туул голд баруун талаас нь цутгах ба хотын барилгажилтын байдлаас шалтгаалан баруун гольдрол нь бүрэн хаагдсан. Сэлбэ голын ус хуримтлуулах талбай 319 км2. Бусад гол горхиуд мөн адил агаарын хур тунадсаар тэжээгддэг бөгөөд Туул, Сэлбэ зэрэг голуудын урсац багасаж голын татмын чийглэг хөрс хатаж хуурайших, Сэлбэ, Толгойтын голын эх орчмын нуга, намгийн цэвдэгт хөрс хатан хуурайшиж, цэвдэг гэсэж хөрсний суулт өгөх зэрэг үйл явц нэмэгдэж байна.




*Зураг 6. Төслийн талбайн гадаргын усны зураглал*

Туул голын эх нь уулын тунгалаг, цэвэр, цэнгэг маш бага эрдэсжилттэй олон голууд

цутгадаг, хүний үйл ажиллагааны нөлөө харьцангуй бага учраас, бохирдол бага, байгалийнхаа унаган төрхөөрөө байгаа юм. Харин нийслэлийн Налайх хот орчмоос эхлэн урсгалынхаа дагуу антропоген, техноген нөлөөлөлд өртөж, найрлага, шинж чанар нь өөрчлөгдөн, бохирдож байгалийн аясаар нөхөн сэргэх боломжгүй болж байна. Туул голын усны чанар найрлагыг үе үеийн судлаачид харьцангуй сайн судалж ирсэн байдаг. Туул голын эхийн цутгал голууд ихэвчлэн нэн цэнгэг буюу 100 мг/л хүрэхгүй маш бага эрдэсжилттэй, маш зөөлөн ихэвчлэн 1.0 мгэкв/л хүрэхгүй хатуулагтай, хүний үйл ажиллагаанд бага өртсөн уулын тунгалаг, цэвэр устай байснаа эрдэсжилт нь урсгалынхаа дагуу алгуур өсөж, түүнчлэн Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжаас гарсан бохир ус нийлснээс дооших хэсэгт бохирдолтын үзүүлэлтүүд эрс огцом нэмэгдэж “Бохирдолттой, маш их бохирдолтой ” гэсэн ангилалд шилжиж, голын усны бохирдол эрс ихсэж байгаа нь ТЦБ-ийн хэвийн бус үйл ажиллагаанаас шалтгаалж байгаа нь илт байна. Туул голын усны чанар Лүнгийн гүүрний орчим 2006 онд III зэрэг буюу “Бага бохирдолтой“ гэж үнэлэгдэж байсан бол 2007 онд IV зэрэг буюу “Бохирдолтой“ гэж үнэлэгджээ.

### *2.4 Газрын доорх ус*

Төслийн талбай орших бүс нутгийн хувьд газар доорх ус орших байдлаараа нүх сүвийн, ан цавын гэсэн үндсэн 2 хэв шинжид хуваагддаг. Гидродинамикийн горимын хувьд янз бүрийн настай чулуулаг дахь ан цавын ус голдуу шахалтгүй нөхцөлд оршино. Газрын доорх усны нөөц маш жигд биш тархацтай бөгөөд тектоник хагарлыг дагаж ус гадагшлуулагч чулуулаг ихээхэн ан цавархаг байдаг.

*Газрын доорх усны чанар*

Монгол улсын Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Туул голын сав газрын захиргаа, Богд хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг” (Хавсралт 1), Туул голын сав газрын захиргааны даргын 2016 оны 9 дүгээр сарын 29-ний А-45 дугаар тушаал (Хавсралт 2)-ыг тус тус үндэслэн Богд хан уулын дархан цаазат газрын улсын тусгай хамгаалалттай газар нутагт усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулсан.

*Булаг шанд*

Богд хан уулын дархан цаазат газарт нийт 18 булаг шанд тоологдсоноос байнгын устай 14, түр зуурын урсацтай 4 байна. Эхийг нь хашиж хамгаалсан 2, хамгаалах шаардлагагүй буюу байгалийн тогтоцын хувьд хамгаалагдсан 5, эхийг нь зайлшгүй хашиж хамгаалах шаардлагатай 5 булаг байна. 2016 онд явуулсан усны тоо бүртгэлийн ажлын үр дүнд өмнө нь бүртгэгдээгүй орхигдсон байсан Залаатын булаг, Залаатын амны арын булаг, Бумбатын доод булаг, Төр хурахын булаг, Хүрхрээгийн амны булаг, Зүүн дэлгэрийн булаг, Их цагааны булаг, Арцатын булаг гэсэн 8 булаг шинээр бүртгэсэн.

*Худаг*

Богд хан уулын дархан цаазат газарт нийт 369 худаг тоологдсоноос төслийн талбайн орших Арцатын аманд 20 худаг байна.




*Зураг 7. Төслийн талбайд ойр байрлах худаг*

## *2.5 Хөрсөн бүрхэвч*




Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөл барих төслийн талбай, түүний орчмын бүс нутаг нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Бага Хэнтийн нурууны салбар уулс, Туул голын ай сав , байгалийн бүсшилээр ойт хээр, хөрс газарзүйн бүсээр Уулын хархүрэн хөрсний бүсэд багтах бөгөөд төслийн талбайд хэмжээнд нэг төрлийн Уулын хархүрэн хөрс тархсан байна.

Уулын нугын хар хүрэн хөрс, уулсын хоорондох нарийн ам хоолой, нарийвтар хөндийгөөр делювийн карбонатлаг хөвсгөр хурдас дээр тархана.

### *2.6 Ургамлан бүрхэвч*

Төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Богдхан уул нь Хэнтийн уулархаг тайгын урд, Монгол-Дагуурын ойт хээрт оршдог. Эндэхийн ургамал аймагт бүхэлдээ Өмнөд Сибирийн тайга, өндөр уулын элементүүд гол үүрэг гүйцэтгэнэ. Богдхан уулын ургамлыг бүслүүрээр хувааж үзвэл уулын хээр 28.8%, ой 52%, өндөр уул 19.3% байна.




Хээрийн ургамалжилт нь байрлал, зүг зовхисын ялгаа, өндрийн түвшнээс хамааран дэд хэв шинжийн түвшинд босоо бүсчлэл үүсгэнэ. Уулын тавиу бэл, хормой, өргөн хөндийгөөр хуурай хээр, ойн доод захыг эмжсэн чийглэг хажуугаар нугат хээр, салбар уулсын чулуурхаг орой, хяр, товгор энгэр дагуу уулын хээр байрлана. Уулын хээрт Ленийн ботууль, нугат хээрт том дэгнүүлт хялганууд зонхилж байхад хуурай хээрт дааган сүүл, ерхөг, биелэг өвс, хазаар өвс зэрэг жижиг дэгнүүлт үетэн түгээмэл тохиолдоно.

### *2.7 Амьтан*

Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг төслийн талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 4-р хороо Арцатын аманд оршино. Тус төслийн талбай нь Монгол орны хөхтөн амьтдын газарзүйн мужлал (Банников, 1954)–аар Хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Хэнтийн тойрогт хамаарна. Хангай Хэнтийн уулын хээрт амьдрагч амьтан тэргүүлэн ойн болон хуурай хээрийн амьтад цөөн байна.

Төсөл хэрэгжих Богдхан ууланд одоо амьдарч байгаа одоогоор олдоогүй боловч гарцаагүй байж болох зарим нэг зүйлийг нэгтгээд 52 зүйл хөхтөн (шавж идэштэн 4, сарьсан далавчтан 5, туулай хэлбэртэн 4, мэрэгчтэн 21, мах идэштэн 13, туруутан 5 зүйл) амьтад тархан байршиж байна. Монгол орны хөхтний зүйлийн бүрэлдэхүүний 37.7%-г эзэлж байгаа нь хөхтний элдэв хэлбэр, зүйлийн тоогоор харьцангүй баян болохыг гэрчилж байна. 52 зүйл хөхтөн амьтдаас зүйлийн бүрдлийн хувьд мэрэгчид хамгийн олон нийт зүйлийн бүрдлийн 40.3%-ийг, махан идэшт амьтад 25.0%, шавж идэштэн 7.7%, гар далавчтан, туруутан 9.6%, туулай хэлбэртэн 7.7 хувийг тус тус эзэлж байна.

### *2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг*

“Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг” төслийн талбай нь Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд оршино. Богдхан уул нь 1778 онд Богд хаант Монгол Улсын үед дархлагдаж байсан, дэлхийн хамгийн анхны Дархан цаазат газар юм. Богдхан уулыг УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор Богдхан уулын дархан цаазат газар хэмээн нэрлэж, 1996 оны 05 дугаар сард ЮНЕСКО-оос Дэлхийн шим мандлын сүлжээнд оруулах шийдвэр гарч, 1997 онд гэрчилгээг олгож байв. Богдхан уулын дархан цаазат газар нь хойд талаараа нийслэл Улаанбаатар хотын Хан-Уул, Баянзүрх дүүрэг, урд талаараа Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумтай хил залгадаг, нийт 41.6 мян.га талбайтай, үүнээс онгон бүс газар нутгийн 17.3% буюу 7115.3 га, хамгаалалтын бүс нь 54.2 % буюу 22291.9 га, хязгаарлалтын бүс 28.5 % буюу 11721.8 га тус тус эзэлдэг. Богдхан уулын орчны бүсийг 2010 онд Төв аймагт, 2012 онд Баянзүрх дүүрэгт тогтоосон бөгөөд харин Хан-Уул дүүргийн орчны бүсийг тогтоогоогүй байна.




*Зураг 8. Төслийн талбайн дархан цаазат газар*

Богдхан уул нь манай орны төдийгүй дэлхийн ууган дархан газрын тоонд зүй ёсоор орно. Монголчуудын эрт дээр үеэс энэ уулыг дархан цаазтай болгон хамгаалж байсны дотор XII-XIII үед Монголын Хэрэйд аймгийн тэргүүн Ван хаан дархлан тахиж Хан уул хэмээн нэрлэсэн гэдэг. Богд уулыг 1778 онд албан ёсоор дархалсан. 1957 онд Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 31 дүгээр тогтоолоор Чойбалсан уул нэрээр дархалж, 1974 онд Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 248-р зарлигаар Богд уул нэрээр дархан цаазат газар болгожээ. Улсын их хурлын 1995 оны 26 дугаар тогтоолоор “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулинд нийцүүлэн дархан цаазат газрын ангиллаар баталгаажуулсан байна.

**Түүх соёлын дурсгалт газрууд:** Дархан цаазат газрын нутаг дэвсгэрт байгалийн өвөрмөц тогтоцтой, түүх дурсгалын газрууд олон бий. Үүнд: Цэцээ гүний оргил, Төрхурахын ам,

Шажин хурахын ам, Залаат, Шавартын ам, Манзуршир хийд, Нүхтийн ам, Зайсан толгой зэрэг түүх соёлын дурсгалыг хадгалсан бүсэд 300 гаруй аж ахуйн нэгж, байгууллага аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байна. Богдхан уулын дархан цаазат газрын Түүх соёл үл хөдлөх дурсгалт зүйлийг тэмдэгжүүлэхэд нийт 197 дурсгал бүртгэгдсэн байна.

### *2.9 Нийгэм эдийн засаг*

Хан-Уул дүүрэг нь 209,524 мянга хүн амтай, 56,874 мянган өрхтэй, 23,584 аж ахуйн нэгж, үйлдвэр, компани, нөхөрлөл, хоршоотой, 42,867 толгой малтай, 482.860 тахиа, 3.610 гахай бүхий эрчимжсэн аж ахуйтай, хүлэмжийн аж ахуй, агро парк бүхий газар тариалан хөгжсөн бүс нутаг юм. Дүүрэг нь 48500 га нутаг дэвсгэртэй, үүнээс 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67,6 хувь буюу 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11,3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт хамаардаг.

**Хүн ам:** 2022 оны жилийн эцсийн байдлаар Хан-Уул дүүрэгт 63967 өрхийн 238511 хүн байнга оршин сууж байна. Нийт хүн амын 113058 (47.4%) нь эрэгтэйчүүд, 125453 (52.6%) нь эмэгтэйчүүд эзэлж байна. Нийслэл хотод оршин суугаа нийт хүн амын 14.9 хувь нь Хан-Уул дүүргийн хүн ам эзэлж байна. Хүн амын нягтралаар авч үзвэл, Хан-Уул дүүргийн нэг км2 нутаг дэвсгэрт 2013 онд 270 хүн оршин сууж байсан бол 2016 онд 317 хүн, 2017 онд 337 хүн, 2019 онд 372 хүн, 2020 онд 389 хүн, 2021 онд 416 хүн, 2022 онд 474 хүн оршин суух болжээ.

**Аж үйлдвэр:** Хан-Уул дүүргийн аж үйлдвэрийн газрууд нь 2020 онд нийт 958.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1184.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны эцэстэй харьцуулахад үйлдвэрлэлт 22.4 хувиар буурч, борлуулалт 14.8 хувиар өссөн байна. Хан-Уул дүүргийн аж үйлдвэр, уул уурхай, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрүүд нь Монгол Улсын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн 5,8 хувь, нийт борлуулалтын 6,0 хувь, Нийслэлийн нийт үйлдвэрлэлтийн 9,5 хувь, нийт борлуулалтын 9,6 хувийг тус тус үйлдвэрлэж байна.

# ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү бүлэгт төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд түүнд өртөх газрын гадарга агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхой тусгана.

Уг төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Тус төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгадахуун нь агаар, хөрс, ус, газрын гадарга, ургамал юм.

### *3.1 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл*

Төслийн талбайд үүссэн агаарын тоос, бохирдол нь салхины зонхилох чиглэлийн дагуу баруун хойноос зүүн урагш чиглэлд тархах боломжтой. Тоосны тархалт тал бүрт 50-100 м орчим газарт унадаг тул тоосжилтоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл түр хугацааны, бага эрчимтэй байна. Харин хийн бохирдлын нөлөөллийн хэмжээ орчны агаарыг зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан бохирдолд хүргэхээргүй юм.

### *3.2 Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл*

- Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх.
- Машин механизм, тээврийн хэрэгслээс бензин, тос тосолгооны материалын асгаралт алдагдал үүсэж усан орчинг бохирдуулахаас сэргийлж машин техникийн засвар үйлчилгээг зөвхөн тогтоосон хатуу хучилттай талбайд хийх.
- Шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүний сав баглаа боодол, тостой даавуу сэлбэг хэрэгсэл (аккумлятор, хаягдал олгой, дугуй гэх мэт)-ийн хаягдлыг ил задгай хаяхгүй байх.

### *3.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл*

- Олон салаа зам гаргахгүй тогтсон нэг замаар зорчих.
- Ажилчдыг засмал зам талбайгаар явахыг сануулсан тэмдэглэгээ байршуулах.
- Бохир ус болон шингэн хаягдлыг агуулах нүх болон хогийн цэгийн байрлалыг газар доорх усны түвшин, хөрсний шинж чанар зэрэгтэй уялдуулан зөв сонгох (объектоос 60м-ээс багагүй зайд, зонхилох салхины доод хэсэгт).
- Шатах тослох материал асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

### 3.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Төслийн талбайн онцлогт тохируулан талбайд тарьсан ногоон байгууламж буюу бут сөөг, зүлэгжүүлэлтийг арчлах, тордох, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.
- Цаашид шинээр барилга байгууламж барих болон хөрс хөндөх хэрэгцээ шаардлага гарсан тохиолдолд өнгөн хөрсөнд агуулагдах нутгийн ургамлын амьдрах чадварыг

нь хэвээр хадгалахын тулд өнгөн хөрс хуулалт, хадгалалтын стандартыг мөрдөж ажиллах.

- Төслийн талбайн ногоон байгууламжийн талбайд тухайн бүс нутагт ургадаг ургамлын төрөл, зүйлүүдийг ашиглах.
- Олон салаа зам гаргахгүй тогтсон нэг замаар зорчих.

### *3.5 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл*

- Ан амьтны тухай хууль, тогтоомжийг биелүүлж, даган мөрдөж ажиллах.
- Төслийн талбай түүний ойр орчмын хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, ахуйн хог хаягдлаас мал амьтан хордож болзошгүй учир үүнээс сэргийлж хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах хэрэгтэй.
- Ажилчдын орон байр, агуулахад элдэв мэрэгчид, шувуу, шавж элбэгших явдлыг хянах, хүн малын халдварт өвчин гарах, тархахаас сэргийлэх.
- Төслийн талбайд мал амьтан орох, тээвэрлэлтийн үед машин техникд дайруулж хорогдохоос сэргийлэх, тээвэрлэлт хийх жолооч нарт зааварчилгаа өгөх

### *3.6 Нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл*

Төслийн бүх ажилчдад ажил үүргийн хуваарьтай нь уялдуулан аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч сургалтад хамруулж байх.

- Ажилчдад болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгөх.
- Анхны тусламжийн хайрцгийг ажлын талбайд бэлэн байлгах.
- Төслийн ажилчид болон дүүргийн иргэдээс гомдол санал ирсэн тохиолдолд хүлээн авч цаг алдалгүй зохих шатанд нь шийдвэрлэж хариу өгч байх.
- Цаашид ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэршүүлж эргүүлэн ашиглах тал дээр анхаарч ажил
- “Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг” төслийн талбай нь Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд оршино. Тухайн бүс нутаг нь Барилгажсан талбайд бүсэд орших тул барилга барих болон ашиглалтын үед ТХГН-т сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

### *3.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ*

- Шинээр зарлагдсан ажлын байрны талаарх мэдээллийг дүүргийн иргэдэд хүргэж байх. Тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх.
- Энгийн хог хаягдал тээвэрлэх гэрээний хугацаа дууссан тохиолдолд тухай бүрд сунгаж ажиллах.
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, хүчтэй шуурга) болоход гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж, ажиллагсдыг сургалтад

хамруулж дадлагажуулах, эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг талбайд байрлуулах.

- Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглох.
- Ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах.
- Ажил олгогч нь ажилтнуудын ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.
- Хан-Уул дүүргийн захиргаатай хамтран ажиллах, жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаарх тайланг хүргүүлж санал авах
- Улс, орон нутгийн төсөвт төлөх татвар хураамжийг цаг тухайд нь төлөх.

**Галын аюулгүй байдлыг хангах талаар:**

- Ажилчдын барилга нь галын дохиоллын системтэй байна.
- Хүний санамсаргүй үйл ажиллагаанаас гал түймэр гарч эдийн засаг, нийгэмд их хэмжээний хохирол учруулж болзошгүй юм. Иймд барилгын бүсэд галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг нарийн төлөвлөн, зохион байгуулахыг удирдлагад зөвлөж байна.

### *3.8 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж*

Нийтлэг шаардлага

- Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь дам байдлаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болно. Иймд ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөл үүсэхээс сэргийлж агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дагаж мөрдөх.
- Ажилтан бүр ажил олгогчийн баталсан жагсаалтын дагуу хөдөлмөрийн нөхцөл, ажил, үүргийн онцлог тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдаж, тэдгээрийг хэрэглэх үүрэгтэй.
- Эрүүл мэнд, ариун цэвэр
- Ажилтнууд өөрсдийн ажлын байранд холбогдох хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааврыг удирдлага болгоно.
- Ажлын байрны аюулгүй ажиллагааны нөхцөлд байнга хяналт тавьж, осол аюул гарсан тохиолдолд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, холбогдох сургалтыг явуулах.
- Ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл болон тохижилтыг дээд зэргээр хангаан, байнгын хяналт тавин ажиллах.
- Ажиллагсдыг ажилд ороход нь эмнэлгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлуулсан байх ба эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулахын зэрэгцээ эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах.
- Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглох.
- Ажилчдын хоол хүнсний аюулгүй байдалд анхаарч ажиллах.
- Хөдөлмөр аюулгүй байдлын дүрмийг чанд даган мөрдөж ажиллах.

# ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

